

ЛИНГВИСТИК ФИЛОСОФИЙН ХОЁР ДАХЬ ҮЕИЙНХНИЙ ҮЗЛИЙН ОНЦЛОГ

Ц.Гомбосүрэн- МУИС-ийн Философийн тэнхимийн профессор

Товч утга: Лингвистик философийн гол хоёр сургуулийн нэг болох Кембрижийн сургуулийг үндэслэгч (ер нь лингвистик философийг үндэслэгч) Л.Витгенштейн, нөгөөх сургууль-Оксфордын сургуулийг үндэслэгч Г.Райл нараас бусад энэ философийн гол гол төлөөлөгчийн үзэл эл өгүүлэлд зориулагдав.

Түлхүүр үг: Хэлний хэрэглээг эмчлэх шинжилгээ. "Тоочигч метафизик". Перформатив ба констатив өгүүлбэр. Хэлэх үйлдлийн хэв маягууд. Ерийн хэл, философи хоёрын харилцаа.

XX зууны философийн ном зохиолуудад "Хэлний тухай философи (philosophy of language-философия языка)" гэдэг нэр томъёоноос гадна "лингвистик философи (хэл шинжлэлийн философи)-Linguistics philosophy" гэдэг нэр томъёог ашигладаг. Энд "хэлний тухай философи" гэдэг ойлголт бол эх хэл, зохиомол хэл аль алиныг хамарсан, тэгэхдээ зохиомол хэлний асуудлыг илүү авч үздэг философид холбогддог. Харин "лингвистик философи" гэдэг ойлголт болбоос эх хэлний асуудлыг онцлон авч үздэг философийг илэрхийлдэг юм.

Лингвистик философи үүсэн, өргөн дэлгэрч ирсэн өлгий нутаг нь Англи билээ. Энэ улсад уг философийн нөлөө бүхий хоёр сургууль байдгийн нэг нь "Кембрижийн", нөгөө нь "Оксфордын" гэдэг тодотголтой. Кембрижийн сургуулийг нь үндэслэгч хожмын Витгенштейн (Людвиг Витгенштейн бол австрийн философич) 1939-1947 оны хооронд Кембрижийн их сургуульд профессороор ажиллаж байхдаа үйл ажиллагааныхаа өмнөх үе дэх төгс хэл зохиох тухай философи судалгааныхаа оронд лингвистик философи судалгаа хийж иржээ. Харин Оксфордын сургуулийг үндэслэгч бөгөөд гол төлөөлөгч нь Г.Райл мөн.

Миний бие Л.Витгенштейний лингвистик философийг авч үзсэн судалгааны үр дүнг «Философи, социологи, политологийн хүрээлэн» гэдэг ТББ-аас зохион байгуулсан монголын философичдын III симпозиумын илтгэлүүдийн эмхтгэлд, Г.Райлын философийг судалсан үр дүнгээ "Тэнгэр" дээд сургуулийн эрдэм шинжилгээний бичгийн №10-д тус тус хэвлүүлэхээр 2008 онд шилжүүлсэн буй. Харин энэ өгүүлэл бол лингвистик философийн хоёр дахь үеийнхний философи үйл ажиллагааг судалж байгаа үр дүнгээ илтгэж буй бүтээл мөн.

Ингээд лингвистик философийн хоёр дахь үеийнхэнд багтдаг зарим нөлөө бүхий төлөөлөгч нарын философи үзлийн агуулгын онцлогийг товч илэрхийлье.

Дж.Уиздом. Кембрижийн сургуулийн нэг томоохон төлөөлөгч Джон Уиздом (Wisdom.1904 онд төрсөн)-ын үзлээр, философи судалгааны зорилт бол ерийн хэлний зарим илрэлийг шүүн тунгаахад оршино. Жишээ нь, "матери" гэх мэт философийн хийсвэр ойлголт бол уг ойлголтыг илэрхийлж буй үгийг мэдрэхүйн зүйлс, биет ба сэтгэллэг илрэл зэргээс салгах замаар тохиолдлын хүслээр бүтээсэн логик зохиомж мөн. Тийм учраас философи бүхэлдээ нэгэн төрөл сүүдэр, үүнд философич хүн өөрийнхөө хүсэл ба ухамсарт биш эрчмээрээ бодит байдлын хана руу буулгадаг тийм сүүдэр мөн.

Дж.Уиздом философийн зорилтыг заахдаа түүнээ аналитик философид холбогдуулж, харин философийг буюу метафизикийг хийсвэр ойлголтуудаас тогтсон сүүдэр мөн гэж дүрслэхдээ сонгодог философийг тухайлж байжээ. Тэгээд "метафизик" гэдэг нэр томъёог шинээр ойлгох ёстой гэсэн байна.

Метафизикийг (логик позитивистууд шиг) устгая гэж биш, харин шинэчилье гэж Дж.Уиздом тийнхүү уриалсан нь тэрээр уламжлалт метафизик дэх "цаг хугацааг хэмжиж болдог", "орон зай 3 хэмжигдэхүүнтэй", "надад бие бий", "өөр хүний зовиурийг бусад хүн мэдэрч чаддаггүй" гэх мэт хэллэгнүүд нэг талаар баримтлаг юм шиг, нөгөө талаар аливаа баримтлаг хэллэгнээс огт өөр юм шиг байдаг гэж үзсэнтэй нь уялддаг. Үүнд, уламжлалт метафизик өөрийн хэллэгүүдийг эцсийн эцэст баримтлаг биш байдалтай

болгодог гэж Дж.Уиздом дүгнэсэн түүний зохиолуудын агуулгаас мэдэж болно. Тэрээр өөрийнхөө давууд үзэж буй метафизикийг ерийн хэлэнд анализ хийх үйл ажиллагаа мөн гэж үзсэн байна. Тийнхүү Дж.Уиздом лингвистик философийн бусад төлөөлөгчийн адилаар: "философи бол номлол биш, харин үйл ажиллагаа (анализ) мөн" гэж асуудалд хандсанаа өөрийнхөө метафизикийн гол зорилт болгожээ.

Дж.Уиздом: "философи бол номлол биш" гэж зарлаж, уламжлалт метафизикийн янз бүрийн хэв маяг дахь номлолыг үл зөвшөөрсөн боловч өөрөө хэл шинжлэлийн зарим үр дүнд дулдуйддаг өвөрмөц философит номлол бий болгосон аж. Тийм номлол нь эмчилгээ шаарддаг өвөрмөц өвчин болох уламжлалт философийн асуудлуудыг сэтгэл судлал (психоаналитик)-д ойр лингвистик философийн үүднээс даван туулсны үр дүн байх аж.

Дж.Уиздом уламжлалт философийн (метафизикийн) ойлголтуудыг баримтлаг биш, философичийн хүслийн үр дүн гэж шүүмжилсэн боловч өөрөө бас субъектив байрнаас лингвистик философи бий болгосон гэж түүнийг үнэлэх үндэстэй. Үүнд, түүний тайлбараар философи өөртөө гурван үндсэн зүйл бүтээдэг нь: а)бодит байдлын биш, харин философичийн өөрийнх нь уг чанарын илрэл болж буй тунгаан бодохуй; б)хэрэг дээрээ логикт хүргэдэг логик анализ; в)хүн хүрээлэлдээ яаж хандаж буй аргын философи хэлбэрийг илрүүлдэг сэтгэлийн төвлөрөл зэрэг ажээ. Чухамхүү энэ гурвын харилцан уялдааны үүднээс хэлний хэрэглээнд гардаг өвчнийг эмчлэх бололцооны тухай Дж.Уиздом өгүүлсэн байна.

П.Стросон. Английн философич Петр Стросон (Strauson 1919 онд төрсөн) бол лингвистик философийн сүүлийн үеийн хамгийн томоохон төлөөлөгч гэж алдаршиж байгаа билээ. Тэрээр анхны бүтээлүүддээ бичихдээ: Б.Рассел болбоос нэрлэгдэгч нь ямагт мэдрэгддэг, гагцхүү чанарыг нэрлэж болдог гэх мэтээр өгүүлбэрийг хэрэглэх, өгүүлбэрийг сонсгох хоёрын ялгааг хольж хутгаж, өгүүлбэрийг хэрэглэх нөхцөл ба арга олон байдгийг дутуу тооцдог хэмээн түүнийг шүүмжилж байжээ¹.

П.Стросон бас үнэний тухай А.Тарскийгийн онолд шүүмжлэлтэй хандаад: үнэний тухай ойлголт болбоос суурь шинж бүхий утгын онцлолтыг илэрхийлдэг биш, харин өгүүлж байгаа юмыг бид (шагших, сайшаах зэргээр) зөвшөөрч буйг илэрхийлэхэд хэрэг болдог гэж үзсэн аж. Тийнхүү тэрээр анхнаасаа эх хэлийг философийн үүднээс авч үзэхэд анхаарлаа төвлөрүүлж байжээ.

Тоочигч метафизик 1959 онд хэвлүүлсэн "Бодгалиуд.Тоочигч метафизикийн тойм" гэдэг зохиол аваас П.Стросоны үндсэн бүтээл нь аж. Тэрээр энэ бүтээлдээ метафизикийг ор тас үгүйсгэх зорилт тавьдаг позитивизмын бүх шатны байр суурийг үл баримталж, харин ч метафизикийн шинэ хэв маягийн тухай философи сурталчилгаа явуулжээ. Үүнд, тэрээр өөрийнхөө дэвшүүлж буй метафизикийг "тоочигч (дескриптив)", харин уламжлалт метафизикийг "засварлагч" хэмээн тодотгодог. Тэгээд тэрээр: засварлагч метафизик (revisionary metaphysics) бол сайн бүтцийг бүтээхийн төлөө байдаг гэжээ. Ийм шүүмжлэлт үзэл нь уламжлалт онтологи болбоос "матери", эсвэл "санаа", эсвэл далдлаг (трансценденталь) "дээд ахуй" гэх мэт ямар нэг объектив, субстанцлаг зүйлийг жинхэнэ бодит байдал, "сайн бүтэц" хэмээн зарладгийг тэрээр үл зөвшөөрдгийн илэрхийлэл болж өгдөг. Харин П.Стросоны өөрийнх нь метафизик бол хэлийг, бүр тодорхой хэлбэл англи хэлийг онтологичилсны үр дүн юм (угтаа ерийн хэлийг онтологичилж буй үед дурын эх хэлийг, тухайлбал англи хэлийг онцолж буйг өрөөсгөл гэж үзэх үндэсгүй нь ойлгомжтой. Яагаад гэвэл тухайн хэл, бусад хэл хоёр харилцан орчуулагдаж, аль ч хэлний агуулга нь өөрийнхөө тээж буй мэдлэгийн цогцтой нэгдмэл байдаг билээ).

П.Стросоны үзлээр, өөрийнх нь дэвшүүлсэн "тоочигч метафизик" болбоос ертөнцийн тухай бидний бодлын жинхэнэ бүтцийг илрүүлэгч байх ёстой. Гэхдээ

¹ См.об этом напр.: А.Ф.Грязнов. Стросон.-Современная западная философия. Словарь, 2-ое изд., преработанное и дополненное. М., 1998; Т.Хилл. Современные теории познания. Пер. с англ. М., 1965, с. 499-500.

П.Стросон "бодлын бүтэц" гэж ярихдаа хэрэг дээрээ хэлний бүтцийг тухайлдаг байна. Яагаад гэвэл бодлыг авч үздэг найдвартай арга бол тухайн бодлыг илрүүлдэг аргыг авч үзэхүй байдаг хэмээн П.Стросон үзсэн аж. Тэрхүү илрүүлдэг арга нь зохиомол хэл биш, харин эх хэл, лингвистик философичдын онцлон нэрлэдгээр ерийн хэл байдаг. Тэгээд философид найдвартай ганц багаж байдаг нь ерийн хэлэнд явуулдаг анализ (шинжилгээ) мөн гэж тэрээр үзсэн ажээ.

Хэлний тухай аналитик философийн анхны төлөөлөгчид логикийн хэлийг онцолж байсныг П.Стросон үл баримтлахдаа үндэслэгээ болгосон арга зүйн гол зарчим нь **логик бол ерийн хэлийг гуйвуулагч мөн** гэдэг үзэл болой. Түүний гаргасан жишээнүүдээс дурдахад² үнэн худлын хамаарлын логикт: "хэрвээ... бол... мөн" гэдэг илэрхийлэл хэллэгүүдийн холбоог тусгадаггүй гэдгээрээ, олонлогуудын тоолол аваас хоосон олонлогуудаас ерөнхийлөл бий болгодгоороо ерийн хэлнээс тус тус хэлтийдэг. Тэгээд тэрээр логик, ерийн хэл хоёрын ан цавыг битүүлэн засах зарим хэрэгслийн тухай өгүүлжээ³. Жишээ нь: 1. "утга (meaning)", "хамаатуулга (refence-относение) гэдэг хоёр ойлголтыг ялгаж, ингэснээрээ хуурамч хэллэг, тоочилтыг экзистенциаль (бодит) хэлний зохиомол хэлбэрүүд мэт дүрслэхийг зогсоох; 2. үнэн байх, худлаа байх, утгагүй байх гурвалыг устгаж, ингэснээрээ утга бүхий зөндөө олон өгүүлбэр үнэн ч биш, худлаа ч биш байдгийг зөвшөөрөх бололцоо бүрдүүлэх гэх мэт юм (туршлага суугаагүй уншигч нарт санаа өгөх зорилгоор өгүүлэхэд өгүүлбэрийн янз бүрийн хэв маяг дотроос зөвхөн хүүрнэх өгүүлбэр л нэг бол үнэнийг, эсвэл худлааг илэрхийлэх үйл бүхий байж, бусад хэв маягийн өгүүлбэрт тийм үйл байдаггүй билээ. Жишээ нь: "та хэдэн настай вэ?", "энх тайван мандтугай", "чи боль", "сайн сайхныг ерөө" гэх мэт өгүүлбэрийг агуулгаараа үнэн юм уу худлаа гэх аргагүй байдаг).

П.Стросоны "Бодгалиуд. Тоочигч метафизикийн тойм" бүтээл хэвлэгдсэн нь философи дахь "шинэ эриний эхлэл боллоо"⁴ хэмээн зарим зохиогч зарласан нь холбогдох үндэслэгээ бүхий байдаг. Яагаад гэвэл аналитик философи бүхэлдээ, тухайлбал, түүний сүүлийн үеийнх нь бөгөөд маш чухал нэг салбар нь болох лингвистик философи болбоос метафизик, бясалгагч (спекулятив) уламжлалд илт эсрэг хандаж ирсэн байхад П.Стросон метафизикийг уламжлалт хэв маягаас нь өөрөөр боловч бүтээж байгаагаа зарласан нь зарим хүмүүст лингвистик философийг үгүйсгэж буй мэт сэтгэгдэл төрүүлсэн аж. Гэвч угтаа П.Стросоны шинэ метафизик нь лингвистик философийг үгүйсгэсэн биш, харин энэ философийг метафизикийн өвөрмөц хөрс суурь бүхий байдаг хэмээн харуулсан байна. Тэгж П.Стросон харуулдаг философи ойлголт, үндэслэлүүд нь юу юу болохыг бид энэ удаад авч үзье.

Бодгалиуд ба универсалиуд П.Стросоны боловсруулсан тоочигч метафизикийн үүднээс үнэн юм уу худлаа байж чаддаг янз бүрийн бодгаль (сингуляр) бататгал болбоос хэлэнд суурь гүйцэтгэл (роль) бүхий байдаг. Хэлэхүй дэх (яриан дахь) аливаа бататгал бололцоо, янз бүрийн баримтын тухай үнэн хэллэгүүдийг бий болгох механизмууд гэх мэт аваас хэл орших суурь нөхцөл нь, юмыг мэдээллээр танин мэдэхүйг болон мэдлэг дэх хийсвэр онолуудыг туршлагаар үндэслэхийг хэлэхүйн үүднээс хангаж өгдөг баталгаа нь тус тус болж өгдөг. Харин хэлэн дэх асуух, санал тавих, ёсорхох зэрэг бусад хэрэглээ нь хэлэхүйн анхдагч бататгал хэлбэрүүдээс үүсмэл, хоёрдогч шинжтэй байдаг. Бататгалын үнэн худлыг тогтоодог үйл явц болбоос бататгаж буй юмны тогтвор ба адилслыг хангадаг. Өөрөөр хэлбэл, бататгалын адилслын асуудал гарч ирдэг. П.Стросон энэхүү асуудал ба түүнийг шийдвэрлэх нөхцөлд анхаарлаа хандуулж байжээ. Тэгээд: хэлэнд хоёр семантик үйл байдаг юм байна гэсэн дүгнэлтэнд тэрээр хүрсэн аж. Тэдгээр нь үзүүлж заах, тоочилт хоёр юм. Энэ

² Энэ тухай бичсэн П.Стросоны бүтээл: P.F.Strawson. Introduction to logical theory. London and New York. 1952, p.82, 109 гэх мэт
³ Энэ тухай мөн дээр дурьдсан бүтээлийн 170, 184 дэх талд үзнэ үү.

⁴ Жишээ нь энэ тухай: E.A.Burtt. Descriptive metaphysics. -Mind, 1963, vol.72, №285 бүтээлийн 18 дахь талд үзнэ үү.

хоёрын хослол нь бататгал хэллэгүүдийг бий болгон ашиглах бололцоог хангаж, улмаар онтологи ач холбогдол бүхий мэдээллийн ажлыг хэл хийдэг болгодог хэмээн П.Стросон бичсэн байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл: бодгаль бататгалууд бүтцэндээ объектийг заагч илэрхийллийг буюу бодгаль илэрхийллийг багтааж, бас өгүүлэгч (тоочигч) илэрхийллүүд аваас заагдагч объектуудыг ангилж, тэдгээр объектийн шинж байдлаар тодорхойлогдож байдаг гэсэн үг юм. Тэгээд П.Стросон "бодгалиуд", "универсалии" гэдэг хоёр категорийг онцолдог болжээ. Тэдгээр нь хэлний үүднээс ялгаа нь илүү заагддаг, тийнхүү хэл зүйн шинж бүхий категориуд мөн. Эдгээр категори хэл зүйн илэрлээрээ ямар ялгаа бүхийд П.Стросон анхаарлаа бас хандуулсан байдаг. Үүнд, түүний бичсэнээр бодгалиуд анхандаа "энд цастай" гэдэг маягийн заагч хэллэгүүдээр дамжиж тунгаан бодохуйд орж ирж, тэдгээрт субъект, предикат хоёрын (өөрөөр хэлбэл тухайн онцолсон юмны талаархи ойлголт, тэр юманд хамаарах эсэх нь яригдсан шинж байдлын талаархи ойлголт хоёрын) ялгааг заах шаардлага гардаггүй.

Бодгалиуд, универсалии хоёрын тус тусын онцлогийг П.Стросон авч үзсэн байна. Ингэхдээ тэрээр "бүрэн бэлгэдэл (символ)", "бүрэн биш бэлгэдэл" хоёрыг логик позитивизмын зарим төлөөлөгч (нэн түрүүнд Б.Рассел) зааглан тайлбарласныг арга зүйн хувьд уламжилжээ. Үүнд, П.Стросоны бичсэнээр⁵ бодгалиуд бүрэн, харин универсалийнууд бүрэн биш байдаг. Универсалийнууд өөрийгөө тээгчээс зохиомлоор хийсвэрлэсэн янз бүрийн шинж, харилцааг илэрхийлэн эзэмдэгийн хувьд бүрэн биш байдаг. Гэхдээ универсалиуд ямар нэг тодорхой объектуудад хамаатдаггүй ч гэсэн бодит байдлын тухай аливаа тунгаан бодохуйн зайлшгүй нөхцөл болж өгдөг. Нэгэнт янз бүрийн универсалии бодит хэлэнд байдаг тул тэдгээрийн төлөөлдөг хоёр дахь эрэмбийн бодит байдал байдгийг үгүйсгэж болохгүй. Хэдий тийм боловч бодгаль объектууд суурь онтологи утга учир бүхий байдаг. "Бодгаль объект" гэдэг ойлголт бусад бүх ойлголтыг бололцоотой болгодог үндэс, аливаа онтологийн тулгуур цэг мөн.

"Бодгаль объект", "бодгалиуд", "универсалиуд гэдэг П.Стросоны ойлголтууд утгаа шинжлэх ухаан, философи аль алины үүднээс шинэ агуулгатай биш билээ. Жишээ нь, логикийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл тухайн ойлголтын багтаамжийг ихэсгэвэл (тодруулж хэлбэл тэр ойлголтоор илэрхийлж буй нэг зүйлийг юм уу ижил төрлийн бүлэг зүйлийг илүү олон бүрэлдэхүүн буюу гишүүн бүхий бүлэг зүйлийн тухай илүү ерөнхий ойлголтонд багтаан хамруулж байвал) агуулга нь тойм, бүдэг, өөрөөр хэлбэл бага болдог. Харин тухайн ойлголтын багтаамжийг багасгавал (тодруулж хэлбэл тэр ойлголтоор илэрхийлж буй нэг төрлийн бүлэг зүйлийн нэгийг юм уу заримыг онцлон илэрхийлсэн ойлголтыг анхны ойлголтын багтаамж дотор үүсгэж байвал) тэгж багасган үүсгэсэн ойлголтын агуулга илүү тод, оновчтой, өөрөөр хэлбэл их болдог. Жишээ нь: "цас" гэдэг ойлголтын багтаамжийг ихэсгэвэл "тундас" гэдэг ойлголт үүсэж, энэхүү шинэ ойлголтын агуулга "цас" гэдгийнхээс бага байдаг. Яагаад гэвэл цасны гол онцлогийг заасан мэдлэг энэхүү шинэ ойлголтын агуулгад үл багтдаг. Харин «тундас» гэдэг ойлголт болбоос бороо, цас, мөндөр мэтийн зөвхөн нийтлэг-тэнгэрийн хур мөн буй ерөнхий (тойм) шинжийг илэрхийлдэг. Хэрвээ "цас" гэдэг ойлголтын багтаамжийг багасгаж "хаврын цас" гэх мэт шинэ ойлголт үүсгэх юм бол тухайн шинэ ойлголтын агуулга нь "цас" гэдгийнхээс их байдаг. Яагаад гэвэл ерөөсөө цас гэж юу болох тухай гол мэдлэг дээр хавар ордог цасны гол онцлогийг илэрхийлсэн мэдлэг тэрхүү шинэ ойлголтын агуулгыг бүрдүүлдэг.

Философийн үүднээс авч үзвэл бодгалиуд болбоос бодит байдлыг шууд илэрхийлдэг тул ийм утгаар тэдгээр нь универсалиудаас дээгүүр хэмээдэг П.Стросын үзэл бол номинализмын өвөрмөц нэгэн хувилбар юм.

Тэгвэл шинжлэх ухаан ба философид нэгэнт байдаг онолын үзлүүдийг П.Стросон өгүүлсэн юм бол яагаад тэдгээрийг түүний нэр хаягаар зарлан сурталчлах шаардлага

⁵ Энэ тухай түүний "Individuals: An essay in descriptive metaphysics. L. 1959 номны 180-189 дэх талд үзнэ үү.

гардаг вэ? гэсэн асуулт гарч болно. Тийм асуулт гарсан тохиолдолд өгөх хариу нь гэвэл: английн энэ философич эх хэлний дүрэм, механизм, бүтцийг ашиглах үндсэн дээр асуудлыг авч үзэн тайлбарласан байна. Бодгалиуд бол жич жич юмыг төлөөлдөг хэлний илрэлүүд, харин универсалиинууд бол юм юу болохыг илэрхийлдэг тус тус хэлц (phrases) мөн гэж тэрээр тайлбарлажээ⁶. Үүгээрээ ойлголтуудын багтаамж, агуулга хоёрын харьцаа; нэгж ба ерөнхий (универсалии)-гийн харьцаа зэргийг сэтгэхүй, оюун ухааны хүрээнд тайлбарлаж ирсэн уламжлалт философийн тайлбараас П.Стросоны философи тайлбар ялгагддаг байна.

П.Стросон "бодгаль объект" гэдэг ойлголтыг анхандаа ерийн тунгаан бодохуйд нэлээд ойр төвшинд хэрэглэж, "бодгалиуд (particulars)" гэдэгтээ материаллаг юмс, хүмүүс, түүхэн үйл явдлууд зэргийг хамруулж, тэдгээрээ "универсалиинууд" буюу чанар, шинж, харилцаа зэрэгт эсрэг тавьдаг байжээ. Ертөнц юмсаас тогтож, дэлхийн түүх тус тус үйл явдлаас бүрэлдэж, ийм бодгалиуд бидний ерийн тунгаан бодохуйн судлах зүйл болж байдаг хэмээн тэрээр бичсэн байдаг⁷. Улмаар П.Стросон "тоочигч метафизик" нэртэй онтологио тус тус объектоос болон тэдгээрийг хэлээр тэмдэглэхээс иш аван боловсруулсан аж.

Универсалиинууд бүрэн биш байдаг хэмээн П.Стросон тайлбарласан нь мөн чанарыг танин мэдэж болдог хэмээн "засварлагч метафизикийн" зарим чиглэлд үздэгийг тэрээр үл зөвшөөрсөнтэй нь холбогддог юм. Чухам тиймээс онтологийнхоо суурь ойлголтын утгаар нэгж объектийн тухай П.Стросон авч үзсэн аж.

Нэгж объектийг адилтгах үйлдэл (идентификаци). Нэгж объектийн тухай ойлголт бидний ерийн утгатай ашиглагдаж буй үедээ онтологийн анхдагч, элементэн категори байж чадахгүй юм байна гэсэн дүгнэлтэнд П.Стросон цаашдын судалгаануудынхаа явцад хүрсэн байна. Тэгээд: онтологи бол нэгж объектийг адилтгах маш ярвигтай үйлдэлд (идентификацид) үндэслэдэг гэж үздэг болжээ. Энэ үндэслэлийн агуулгыг илэрхийлбэл: 1) яригч, 2) сонсогч нар бодгаль объектуудыг адилтгахыг, 3) тэдгээрийг адилтгаснаа өөр хооронд нь зохицуулахыг тус тус хэлэхүйн хамаарал шаарддаг. Хэлний хамаарлын явцад бодгалиудыг адилтгах чадвар аваас зүгээр л нэг азтай тохиолдол төдий биш, харин бодгаль объектуудыг манай онтологид багтааж, онолын баримтлалын хэлэхүйн сэтгэхүйг бодит байдалд хамаатуулах зайлшгүй нөхцөл мөн гэж П.Стросон үзсэн байна. Түүний хувьд нэгж объектуудыг адилтгах үйлдэл бол ганц удаа л болдог үйлдэл биш, харин давтагдагч үйл явц, бодгалиудыг янз янзаар дахин дахин мэдэж авч, давтан адилтгадаг байдал мөн. Гэхдээ бодгалиудыг адилтгахын тулд тухайн нэг зүйл бүр дэх өөр өөр онцлогийг илрүүлдэг үйлдэл, өөрөөр хэлбэл бодгалиудын ялгааг заадаг үйлдэл аваас адилтгахын маш чухал нэг тал мөн гэж П.Стросон заажээ. Тэгээд тэрээр "демонстратив (үзүүлэх) адилтгах үйлдэл" гэдэг ойлголт бий болгосон байна. Энэ ойлголтын үүднээс "би", "тэр", "энд", "тэнд", "одоо", "өнөөгийн" гэх мэт илэрхийллүүд объектийг тоочихоосоо заах нь голлодог. Тийм илэрхийллүүдийг П.Стросон бас "деиктик (шууд нотлогч)", "индексэн (тэмдэглэн заагч)" гэх мэтээр тодотгосон байдаг. Энэ нь демонстратив үйлдлийн жич жич аргыг онцолсон нь юм. Тодруулан дурдахад субъектийн бодгаль онцлог, орон зайн юм уу цаг хугацааны нөхцөл зэргээс хамаараад адилтгахын нэг чухал хэв маяг болох заах адилтгах үйлдэл (идентификаци) өөрийн дотооддоо бас жич жич илрэлтэй, үүнд сэтгэл зүйн ба хэлний хүчин зүйлээр нөхцөлдсөн өвөрмөц илэрхийллүүд бүхий байдаг.

Хэлний референциаль (хамаатуулах) үйл. Бодгалиудыг (буюу нэгж объектуудыг) адилтгах үйлдэл (идентификаци) гэдэг П.Стросоны философи баримтлал бол янз бүрийн объектын хоорондын адилслыг илрүүлэхүй биш ээ (хэрэв адилслыг тэгж

⁶ Энэ тухай. Мөн дээрх номны 172 дахь талд үзнэ үү.

⁷ Энэ тухай дээрх зохиолын 15 дахь талд үзнэ үү.

ойлговол универсалиинуудыг бүрэн гэж үзэхэд, мөн чанарыг танин мэдэж чадна гэж зөвшөөрөхөд, өөрөөр хэлбэл П.Стросон тоочигч метафизикээсээ няцахад хүрэх болно). Энэ философи баримтлал аваас нэгж объект тус бүр өөртэйгөө л адилсаж байдаг гэсэн санааг илэрхийлдэг.

Харин "дан ухамсар", "бодгаль ухамсар", "бодгаль туршлага" зэрэгт адилтгах үйлдэл хийж болдоггүй. Яагаад гэвэл бид өөрсдийгөө үйлдэл хийж байна, бие биетэйгээ үйлдэл бүхий байна, хүн төрөлхтний ерөнхий уг чанарт зохьцон бид үйлдэл хийж байна гэж бид сэтгэж буй үедээ бие биеэ бодгаль гэж үздэг гэж П.Стросон бичжээ.

Тийнхүү П.Стросон нэг талаар адилсал объектив юмст хамаардаг гэж, нөгөөтэйгүүр тэр (адилсал) нь хүнээр заавал дамждаг, бүр тодруулж дурдвал заавал хэлний ачаар хэрэгждэг гэж үзсэн байна. Тэгээд хэл бол хамаатуулах (референцийн) үйл бүхий байдаг тухай тэрээр авч үзсэн байна. Өөрөөр хэлбэл П.Стросоны бичсэнээр, хэл бол зохих объектууддаа шууд хамаардаг жич жич тэмдэгнээс тогтдог референциаль (хамаатуулах) функци бүхий байдаг. Чухамхүү энэ функци болбоос бодгалиудын адилслын үндэс болдог. Жишээ нь: хүн, газар нутаг, цаг хугацаа зэргийн тусгай нэр, тоочдог илэрхийллүүд зэрэг болбоос бие биеэсээ салангид байхдаа нэгж объектуудыг оновчтой үл зааж, онтологи утгаар бүрэн биш байдаг.

Жинхэнэ бодгаль юмс ямар ямар шинж ба онцлог бүхийг илрүүлэх тоочилт ямар байх ёстойн тухай Б.Расселийн үзлийг П.Стросон баримтлаад: тийм тоочилт референциаль үйлээ хэрэгжүүлэхийн тулд нэмэлт мэдлэг өөртөө шаарддаг гэж тайлбарлажээ. Үүнд: бодгальчлал утгаа объектийг оновчтой илэрхийлж дийлдэггүй. Жишээ нь, "тийм нэгэн эцэг" гэдэг бодгальчилсан тоочилж нэмэлт мэдлэггүй бол тодорхой хүнийг үзүүлж заадаггүй. Тийнхүү аливаа бодгальчилсан тоочилт болбоос холбогдох объектийнхоо хосгүй байдлыг илтгэдэг биш юм. Яагаад гэвэл тэрхүү тоочилтонд хамаарах өөр нэг юм уу хэд хэдэн объект (хамтын зохиогч, хуйвалдагч, бүлэглэсэн алуурч гэх мэт) байж болдог.

Аливаа нэр референциаль чадвартай байдаг тухай уламжлалт үзлийг П.Стросон буруу гэж үзжээ. Жишээ нь, тухайн бодгаль нэр хэнийг, юуг тэмдэглэж байгааг мэдэхгүй байгаа хүн тодорхой объектыг зөв зааж чаддаггүй.

Орон зай-цаг хугацааны тогтолцоо бол объектийг бодигальчлах суурь тогтолцоо мөн гэж П.Стросон үзсэн юм. Үүнд, түүний бичсэнээр объектийг бодгальчлах хэлний хэрэгслүүд аваас уг объектийг адилтгахад хүч хүрдэггүй. Адилтгах нь объектууд хязгаартай байх (локализации)-ыг шаардаж, харилцааны нэгдмэл тогтолцоонд тэдгээр тус бүрийн эзэлдэг байр суурийг зааж байдаг. Тэрхүү нэгдмэл тогтолцоо нь орон зай, цаг хугацааны тогтолцоо мөн. Чухам орон зай-цаг хугацааны тогтолцоонд бодгаль объект бүхэн бусад объект тус бүртэй өөр өөрийнхөөрөө харьцдаг.

Тийнхүү П.Стросон мэдлэг, бодит байдал хоёрын адилсах харьцаанд объектив шалтгаан байхыг ор тас үгүйсгэхээс зайлсхийж, харин тэр харьцаанд орон зайн ба цаг хугацааны хүчин зүйлс чухал нөлөө бүхий байдаг гэж үзжээ. Гэхдээ мэдлэг, бодит байдал хоёрын адилсах харилцааны зайлшгүй нөхцөл нь орон зай-цаг хугацааны тодорхой тогтолцоо болж өгдөг байдал аваас гагцхүү хэлэх (ярих) хамаарлаар хангагддаг гэж лингвистик философийн энэ төлөөлөгч үзсэн юм. Түүний бичсэнээр бодгаль туршлага бол бодгаль хүнийх байж, бодгаль хүмүүсийн гол гол танин мэдэхүйн үндэслэл субъектив шинжтэй байдаг нөхцөлд объектив мэдлэг бүрэлддэг. Эндээс үзвэл П.Стросоны "объектив мэдлэг", "объект" гэдэг ойлголтууд аваас "засварлагч метафизик" дэх догматик онтологи утгатай биш, харин арга зүйн хувьд И.Кантын субъективизмийг санагдуулдаг, гэхдээ агуулга нь гносеологийн биш, харин лингвистик (хэл шинжлэлийн) анализын шинжилгээний үр дүн болж ирсэн тийм утга бүхий юм. Тэгээд бас П.Стросон объектийн тухай мэдлэгийг ганц субъектийн лингвистик анализын үр дүн гэж үзэхийг учир дутагдалтайгаар ойлгож, харин уг мэдлэгийг бодгаль хүмүүсийн туршлагын солилцоо, тэдний хамаарлын (коммуникацийн) үр дүн, өөрөөр хэлбэл интерсубъектив чанартай байх ёстой хэмээн үзжээ.

Объектийн тухай мэдлэгийг фаталист объективизм, солипсизмын явцуурал аль алинаас хамгаалсан нь танин мэдэхүйн онол дахь П.Стросоны нэг гавъяа мөн. Гэхдээ

мэдлэгийн объектив шинж, субъектив оролцоо хоёрт зөвхөн хэлний хүчин зүйл шийдвэрлэх ач холбогдолтой байдаг гэж үзээд бусад төрлийн хүчин зүйл тийм шийдвэрлэх ач холбогдолтой байж болохыг философидоо үл харгалзсан нь П.Стросоны лингвистик философийн нэг дутагдал юм.

Дж. Остин. Оксфордын сургуулийнхан дотор онолын нөлөөгөөрөө П.Стросоны дараа болон зарим талаар түүнтэй эн чацуу яригддаг философич бол английн философич Джон Остин (Austin. 1911-1960) мөн. Тэрээр бас орчин үеийн формаль биш логикийг үндэслэгч ажээ. Энэ нь Дж. Остин сэрэл, хүртэхүй хоёрын агуулга бидний танин мэдэхүйн үйлдэлд шууд орж ирдэг тухай үзлийг үл зөвшөөрч, ийм үзлийнхээ үүднээс эх хэл, үгийг хэрэглэхүй болбоос логикийг эвддэг тохиолдол бүхийг илрүүлэх зорилт тавьж ирсний нь үр дүн мөн гэж судлаачид үнэлдэг юм.

Философийн зорилтыг томъёолсон нь. Философи судалгааны гол зорилт бол ерийн хэлний илэрхийллүүдийг цэвэрлэх ажиллагаа мөн гэж Остин үзсэн байна. Түүний хувьд эл үйл ажиллагаа бол өдөр тутмын хэлний логик бүтцийг шинжлэх ажиллагаа байдаг. Тэгээд: асуудал будлиантай үедээ философид хамаарч, харин тэр нь яв цав болбол шинжлэх ухааных болдог гэж энэ философич дурдсан байдаг. Түүний ийм үг нь асуудлыг агуулгын буюу танин мэдэхүйн үүднээс шийдвэрлэх биш, харин эх хэлний утгын үүднээс оновчтой дэвшүүлэн, оновчтой тайлбарлахыг онцолсон байдаг.

Хэл, үйлдэл хоёрын холбоо. Дж.Остин философи, шинжлэх ухаан зэрэг өөр өөр хэв маягийн онолын асуудлыг яагаад дээр дурдсанчлан эцсийн эцэст хэлний асуудал болгосон бэ? гэсэн асуулт гарах үндэстэй. Үүнд холбогдуулан товч тайлбар өгөхөд: тэрээр эх хэлийг, тухайлбал үгийг, бас өгүүлбэрийг тодорхой төрлийн үйлдэл гэж үзсэн байна. Дж.Остины өөрийнх нь гаргасан жишээг дурдахад "гэрлэлт батлуулна гэдэг бол хэдэн үг хэлэхүй мөн". Тодруулан дурдахад⁸ хэд хэдэн үгийг хэрэглэн хэлэх нь тодорхой үйлдлийн гол үйл болж өгдөг нь гэрлэлт батлуулахад шууд холбогддог. Христос шашны уламжлал дагуу сүйт хархүү гэрлэлтээ батлуулж буй яг тэр агшинд эрүүл саруул бөгөөд хүнтэй сууж байгаад салсан биш зөвхөн тийм эмэгтэйтэй ёслол үйлдэж, холбогдох үг сонсож, үгээ хэлж байдаг. Ийм утгаар үг бол үйлдэл мөн. Тэгэхдээ үг гагцхүү тодорхой оновчтой хэрэглэгдэж байж үйлдэл болдог. Энд үг биш, харин үгийн хэрэглээг оновчтой байх ёстойн тухай Дж.Остин ярьдаг. Үгс бол салангид ганцаар байхдаа биш, харин хоорондоо холбогдож, өгүүлбэр болж буй нөхцөлдөө жинхэнэ үйлдэл болж байдаг гэж Дж.Остин үзсэн юм. Тэгээд: өгүүлбэр олон янз байдаг нь үйлдэл олон янз байдаг гэсэн үг мөн хэмээн тэрээр тайлбарлажээ.

Дж.Остин хэлэх үйлдлийн явц дахь өгүүлбэр олон хэв маяг бүхий байдгийг анхан үеийн бүтээлүүдээ авч үзсэн байдаг. Нэн түрүүнд перформатив ба тоочигч (констатив) хоёр янзын өгүүлбэрийг онцолжээ⁹. Ингэхдээ тэрээр өгүүлбэрийг "хэллэг" гэж нэрлэсэн нь элбэг байдаг. Дж.Остин болон түүнийг залгамжлагч нар перформатив өгүүлбэрийг (хэллэгийг)товчоор "перформатив" гэж нэрлэсэн нь дайралддаг. Бас хэл шинжлэлийн тайлбар толинуудад ийм товч томъёог ашигласан нь тааралддаг билээ¹⁰. Перформатив өгүүлбэр, товчоор перформатив (латины *performato*-үйлдэж байна гэдэг утгатай үг) бол үйлдэл, үйл явдалд дүйж байдаг хэллэг мөн. Дж.Остины тайлбараар перформатив өгүүлбэр аваас үйлдлийг мэдээлдэг биш, харин өөрөө үйлддэг байж, агуулгаараа үнэн юм уу худлаа гэж тогтоогддоггүй онцлогтой. Жишээ нь: "би амалъя" гэхэд тэр нь "амалсан", "амлаагүй" гэсэн аль ч утгатай биш байж, харин амлаад тодорхой үйлдэл хийх тийм илэрхийлэл мөн. Перформатив өгүүлбэр бол үнэн юм уу худлаа биш, харин амжилттай юм уу амжилтгүй (бүтэлгүй) байдаг.

Харин тоочигч (констатив) өгүүлбэрүүд бол үнэн юм уу худлаа байж болдог гэж Дж.Остин бичсэн буй. Жишээ нь: "бид маргаан үүсгэнэ" гэвэл (үнэн юм уу худлаа) тоочигч өгүүлбэр мөн.

⁸ См. об этом напр.: Джон Остин. Избранное. М., 1999, с.20-23

⁹ См. об этом напр.: там же, Лекция I

¹⁰ См. напр.: Лингвистический энциклопедический словарь. М., 1990, с.372-373

Дж.Остин онолын үйл ажиллагааныхаа цаашдын явцад хэлэх үйлдлийн тухай онол боловсруулжээ. Тэгээд хэлэх үйлдлийг дараах хэв маягуудад хуваасан байдаг¹¹. Үүнд: а).Локутив үйлдэл буюу локуци (locutions). Энэ бол утга нь өөрийнхөөрөө илэрдэг хэлэх үйлдэл мөн. Локуци бол ерөнхийдөө зохих утга ба зохих тэмдэглээ (референци) бүхий өгүүлбэрийг хэрэглэхүй мөн гэж Дж.Остин бичсэн байдаг. б).Иллокутив үйлдэл буюу иллокуци (illocutions). Энэ бол үг хэлэнгээ юм бүтээхүй, өөрөөр хэлбэл хэлний янз бүрийн үйлийн (асуулт, үнэлгээ, уриалга, сэрэмжлүүлэг, санаачлага гэх мэтийн) аль нэгийг хэрэгжүүлэхүй мөн. Тийнхүү иллокуци аваас мэдэгдэж байж гүйцэлдүүлэх (конвенциональ) арга бүхий хэлэх үйлдэл мөн. в).Перлокутив үйлдэл буюу хэлснийг мэдэж авч буй хүний мэдрэмж, бодолд онцолсон нөлөө үзүүлдэг хэлэх үйлдэл мөн. Жишээ нь: үнэмших, эрхэнд нь орох, айх, мухардах зэрэг үйлдэлд хүргэдэг хэлэх үйлдэл бол перлокуци мөн.

Хэлэх үйлдлийн ийм гурван хэв маягийг тодорхой жишээнүүд дээр Дж.Остин тайлбарласан юм¹². Тухайлбал дараахь жишээнүүдийг тэрээр гаргажээ. Үүнд:

"А" үйлдэл буюу локуци

"Тэр эмэгчинг бууд" гэж тэр надад хэлсэн.

Энд "тэр эмэгчинг" гэдэг нь тэр амьтанг төлөөлж, "бууд" гэдэг нь буудахыг шууд тухайлж байна.

"В" үйлдэл буюу иллокуци

Эмэгчинг нь буудаарай гэж тэрээр надад хандав (эсвэл зөвлөв, тушаав гэх мэт).

"С.а" үйлдэл буюу перлокуци

Эмэгчинг нь буудах ёстойд тэр намайг итгүүлэв.

"С.в" үйлдэл буюу перлокуци

Эмэгчинг нь буудах аргагүйдсэн байдалд тэр намайг хүргэв.

Залуу уншигч нарт хандан хэлэхэд өөр өөр хэлний бүтэц, зохион байгуулалт бие биеэсээ ялгаатай байдаг тул Дж.Остины гаргасан жишээг монгол хэлнээ ийнхүү буулгасан маань учир дутагдалтай байхыг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ нэг чухал философи санаа тэдгээр жишээнд байгааг дурдахад өөр өөр хэллэг буюу өгүүлбэрийн янз бүрийн хэв маяг тус бүр аваас үйлдлийн холбогдох тодорхой тодорхой хэв маягтай харгалзан уялдаж байдаг.

Тийнхүү Дж.Остины тайлбарын үүднээс хандвал локутив хэлэх үйлдэл нь мэдээлэн тэмдэглэх (референциаль) үйл бүхий байж, иллокутив хэлэх үйлдэл нь хэлснийг хамаарлын (коммуникатив) хүчтэй болгодог. Янз бүрийн ассертив (сэдэв ба үндэслэгээнүүд), декларатив (илэрхийллүүдийг хамаарал болгон ашиглах холбогдох дүрмүүдийг бий болгогч) дефиници (тодорхойлолт), директив (асуулт) зэрэг бол иллокутив цогцолборыг бүрдүүлдэг гэсэн тайлбарыг тэрээр хийсэн юм. Улмаар тэрээр: янз бүрийн иллокуци холбогдох перлокуцитай баттай хослохоороо тодорхой хамаарлын нийтлэгийг буюу "хэлэн тоглоом" бүрдүүлдэг гэж үзсэн юм.

Локутив, иллокутив, перлокутив хэллэгүүд заавал тусдаа илэрдэг биш, харин тэдгээр нь нийлмэл өгүүлбэрийн хэлбэрээр нэгдмэлээр хэрэгжиж болдгийг Дж.Остин бас жишээ гарган тайлбарлажээ. Үүнд: "би... гэж үзэж байна", "дарга... хэмээн тушаалаа", "тэр хүн... гэж амлав" гэх мэт хэллэгийн гурван цэгэнд нөхөгдөх хэлц нь локутив хэлэх үйлдэл, гурван цэгийн өмнө хойно буй хэлцүүд нь иллокутив хэлэх үйлдэл, харин тухайн хэллэг бүхэлдээ (хэрвээ үйлдлээрээ зорилгоо биелүүлж буй бол) перлокутив хэлэх үйлдэл юм.

Дж.Остин бас фонетик, фатек, ретик үйлдлүүдийн тухай өгүүлжээ¹³. Үүнд: фонетик үйлдэл бол янз бүрийн авиаг хэрэглэдэг үйлдэл мөн. Фатик үйлдэл бол тодорхой үгнүүдийг хэрэглэдэг үйлдэл мөн. Ретик үйлдэл бол фатик үйлдлийг ашигладаг үйлдэл мөн. Тэрээр фатик үйлдэл, ретик үйлдэл хоёрыг харьцуулсан жишээнүүдээс нь дурдъя. Үүнд:

¹¹ См. об этом напр: Джон Остин. Избранное. М., 1999, с.94-95

¹² См. об этом напр: там же, с.89-90

¹³ См. об этом напр: там же, с.85

1. "Би энд байя" гэж тэр хэлсэн. Тэр өөрийгөө энд байхыг хэлсэн.

2. "Зайл" гэж тэр хэлсэн. Намайг зайлаг гэж тэр хэлсэн.

3. "Муур хивсэн дээр цогнойн сууж байна" гэж тэр хэлсэн. Муур хивсэн дээр цогнойн сууж байгааг тэр хэлсэн. Фатик үйлдлийг ретик үйлдэлгүйгээр хэрэгжүүлж болдог бөгөөд харин фатик үйлдэл ашиглахгүйгээр ретик үйлдлийг хэрэгжүүлж болдоггүй хэмээн Дж.Остин бичсэн байдаг¹⁴.

Дж.Остин "фема", "рема" гэдэг хоёр нэр томъёог бас цөөнгүй ашиглажээ. Угтаа эдгээр ойлголт бол хэл шинжлэлийн, тийнхүү шинжлэх ухааны бүтээгдэхүүн юм¹⁵. Харин Дж.Остин эдгээр категорийг хэлэх үйлдлийн тухай философи онолдоо оруулж иржээ. Тэгээд тэрээр: фема бол хэлний нэгж мөн бөгөөд түүний онцлог дутагдал гэвэл утгатай биш, өөрөөр хэлбэл утгат чанарыг үл эзэмдэг байдал мөн. Харин рема бол хэлэхүйн нэгж бөгөөд түүний үндсэн дутагдал гэвэл илт биш, хоосон, бүрхэг байдал мөн гэж бичсэн байдаг¹⁶. Гэтэл хэл шинжлэлийн бүтээлүүдэд бичдэгээр рема бол өгүүлбэр дэх шинэ мэдээг тээгч гишүүн байдаг. Энэ нь бодомжийн онолд ярьдаг түүний (бодомжийн) предикат нь болж буй гишүүн мөн гэж үздэг судлаач цөөнгүй байдаг.

Тэгвэл Дж.Остин яагаад рема, фема хоёрыг хоёуланг нь мэдээлэл (өөрөөр хэлбэл шинэ санаа) тээгч (илрүүлэгч) гэж үзсэнгүй вэ? гэдэг асуулт гарч болох юм. Дж.Остин түүнд яв цав хариулт болох тодорхой тайлбар өгөөгүй байна. Гэхдээ түүний философи ерөнхий үзлийг нь иш үндэс болгон хэлэхэд тэрээр үгийн утгат чанар ба утгыг сонгодог философид заадагчлан тогтворт санаа гэж үзэлгүйгээр харин түүнийг (утгыг) хэллэгийн нөхцлөөс (контекстоос) хамааран бий болж байдаг хэмээн үздэгтэй нь рема ба фемагийн тухай түүний үзэл уялджээ. Чухам тийм, болзмол утгаар фема бол утгатай биш, рема бол илт биш байдаг. Тодруулан дурдахад үгийн утга, өгүүлбэрийн үндсэн санаа (шинэ мэдээ) нь ямагт хэлэх үйлдлийн нөхцлөөс хамаарч байдаг.

Дүгнэн дурдвас Дж.Остин утгат чанарыг хэлэхүйн нөхцлийн конвенциональ дүрмүүдээс хамаардгаар, уялдмал хэллэг (дискурс)-ийн хэлхээнд бий болдгоор авч үзэж, энэ нь фема ба ремагийн тухай өвөрмөц философи санаа тэрээр илэрхийлэхэд хүргэжээ. Дж.Остины боловсруулсан онол нь лингвистик философийн цаашдын хөгжилд, ялангуяа лингвистик прагматикт төдийгүй логикийн зарим салбарт, тухайлбал хэлэх үйлдлүүдийг өгүүлэгчийн интенциональ (тэмүүлэлт) үйлдэл хэмээн тайлбарлагч иллюкутив логикт онцгой нөлөө үзүүлсэн тухай судлаачид бичсэн байдаг.

Ст.Хэмпшайр. Английн философич Стюарт Хэмпшайр (1914 онд төрсөн) бол ерийн хэлэнд анализ хийхдээ нэлээд өвөрмөц ханджээ. Үүнд: *нэгдүгээрт*, Л.Витгенштейн, Г.Райл нарын үзэл дэх бихевиорист (иймд нэгэн төрөл материалист) хандлагаас урьд интроспекционист (иймд ухамсрынхаа янз бүрийн төлвийг өөрөө ажин шинждэг) психологи хандлага Ст.Хэмпшайрын философид илүү баримтлагдсан байна. *Хоёрдугаарт*, утгат чанар бол зөвхөн үгийг хэрэглэх арга мөн гэж үзэхээс зай бариад түүнийг (утгат чанарыг) шалган илрүүлдэг тухай онолын талд зогсжээ. *Гуравдугаарт*, метафизик сэтгэлгээг сэжиглэн хардаагүй нь аналитик философичдын олонхиос Ст.Хэмпшайрыг бас ялгаатай болгосон юм.

Ингээд Ст.Хэмпшайрын лингвистик философи үзлийн агуулгыг товч илэрхийлье. Үүнд, түүний өгүүлснээр орчин үеийн английн философийн (энд лингвистик философийг онцолж буй) онцлог нь нэгдмэл аргаас татгалзсан Дж.Мурын үзлийг давтаж, илт биш байсан зарим ялгааг тодотгоход тусалдаг аливаа барилыг зөвшөөрдөг үзэл мөн. Энэ философи ерийн хэлийг тоочихыг л онцлоод тайлбар хийхэд маш бага анхаарал тавьдаг. Тийм тоочилт аваас ойлгож авахад чухал байдаг ч гэсэн философийн зорилтыг бүхэлд нь төлөөлж чадахгүй билээ. Баттай үнэнийг янз бүрийн илэрхийллүүд

¹⁴ См. об этом напр.: там же, с.86

¹⁵ См. об этом напр.: В.Е.Шевякова. Актуальное членение предложения. Его же. Рема.- Лингвистический энциклопедический словарь. М., 1990.

¹⁶ См. об этом : Джон Остин. Избранное. М., 1999, с.87

хангаж буй нөхцлүүдийг жишин авч үзэхээс философи судалгаа эхэлдэг. Философич хүн тийм жишилтийн үндсэн дээр баттай үнэн гэж юу болохын стандартыг сонгож, өөр өөр хэв маягийн илэрхийллийг хэрхэн хэрэглэх тохиролцоог тэрхүү стандарттайгаа яаж нийцүүлэхийг заахыг чухалчилдаг. Тиймээс философийн сэдэв (тезис) бол үнэнийг тогтоогч янз бүрийн аргыг тайлбарлагч нэг загвар (схем) болгон нэгтгэхэд чиглэдэг. Аливаа үгийг хэрхэн хэрэглэж буйг илрүүлэх нь философийн нэн чухал хяналт мөн ч гэсэн философи түүнээс цааш явах ёстой. Танин мэдэхүйн онол нь хүртэхүй, мэдлэг, санаа бодол зэргийг дурдсан хэллэгнүүдийн хоорондын логик харилцаануудыг, өөрөөр хэлбэл "би мэдэж байна", "итгэл төрж байна" гэх мэт нэр томъёог ерийн хэрэглээ бүхий янз бүрийн хэв маягийн өгүүлбэртэй хослуулан зөв хэрэглэх нөхцлүүдийг хамаардаг болжээ¹⁷.

Логикийн чухал чухал бүтцийг формаль логик тогтолцоонуудаар, тухайлбал Куайны ярьсан маягийн өгүүлбэрүүдээр илрүүлэх бололцоогүй юм. Тийм тогтолцоонууд хичнээн өгөөжтэй байлаа ч гэсэн утгат чанартай байхын тулд ерийн хэлний нэр томъёонуудад хөрвөдөг байх ёстой. Ер нь ямар ч өгүүлбэрийн утгат чанар ерийн хэлний нөхцлөөс хамаармал байдаг.

Тийнхүү Ст.Хэмпшайр ерийн хэлэнд анализ хийж ирсэн философи үр дүнд нэлээд шүүмжлэлтэй хандаж иржээ. Гэвч энэ бол Ст.Хэмпшайр лингвистик философийн хүрээнээс халиад явчихсан гэсэн үг биш билээ. Тэрээр ерийн хэлэнд анализ хийж, энэ чиглэлээр бий болсон чухал чухал ололтыг зөвшөөрч байв. Тухайлбал: логикт авч үздэг өгүүлбэрүүд хэрэглээнд үндэслэдэг тул мөрдлөгөө болдог өгүүлбэрүүд зайлшгүй биш байж, харин үнэн юм уу худлаа байж болдог гэж П.Стросон заасныг Ст.Хэмпшайр баримталжээ.

Утгыг шалган илрүүлдэг тухай онолыг лингвистик философичид ноцтой шүүмжилдгийг Ст.Хэмпшайр дэмжээгүй юм. Түүний үзлээр, уг онол болбоос утгат чанар гэж юу болохыг зохистой тайлбарлахад ихээхэн үр ашигтай байдаг. Тухайлбал эмпирик хэллэгийг илэрхийлдэг өгүүлбэрийг ойлгоно гэдэг бол өөрийгөө илтгэхэд тэр өгүүлбэрийг хэрэглэж болдог янз бүрийн нөхцлийг танин мэдэж болдог гэсэн үг мөн.

"Үгийн утга бол түүний хэрэглэгдэх арга мөн" гэдэг лингвистик философи үзлийг Ст.Хэмпшайр баримтлаагүйн зэрэгцээ хэлийг хэрэглэхдээ ашигладаг аргууд бол утгат чанарыг илрүүлэх түлхүүр мөн гэж тэрээр үзсэн байна. Утгат чанар гадаад ертөнцийн ямар нэг юмыг заадаг боловч түүнд бас субъектив тал байдаг хэмээн Ст.Хэмпшайр бичжээ. Ялангуяа зорилго, хамаатуулга хоёр утгат чанард багтдаг. Утгат чанард тийнхүү субъектив тал байдаг тул бид өөрийнхөө хэллэгний үнэн худлыг хувийн ажиглалт, тунгаан бодохуйг ашиглан тогтоодог хэмээн Ст.Хэмпшайр заасан аж.

Утгат чанарын тухай Ст.Хэмпшайрын үзэл нь метафизик баримтлалуудын тодорхой ач холбогдлыг тэрээр зөвшөөрдөгтэй нь уялдаж байдаг. Тэгээд: философи бол хүн төрөлхтөний мэдлэгийн хязгааруудыг болон туршлага ба бодит байдалд хэрэглэдэг хамгийн ерөнхий категориудыг өөрийнхөөрөө судалдаг хэмээн "Оюун ухааны эрин" гэдэг нэлээд сүүлийн үеийн бүтээлдээ бичжээ¹⁸.

Ерийн хэлийг Ст.Хэмпшайр шинжилсэн онцлог юуг илтгэж байна вэ? гэвэл лингвистик философийн төлөөлөгчид хэлэнд анализ хийж буй арга, тайлбар нь нэлээд бие даасан, эрүүл хайгуул ихтэй, бүтээлч байдгийг тэрхүү онцлог аваас өөрийнхөөрөө харуулдаг.

Н.Малкольм (Malcolm. 1911 онд төрсөн). Америкийн аналитик чиглэлийн философич Норман Мальколм бол Дж.Мур, Л.Витгенштейн нартай харилцаатай байж, улмаар Л.Витгенштейний шавь, залгамжлагч хэмээн зарим судлаачдад үнэлэгдсэн юм. Тэрээр хэд хэдэн бүтээл нийтлүүлсний дотор Дж.Мур, Л.Витгенштейн нарын тухай бичсэн зүйлсээрээ илүү алдаршсан байна. Тэгээд тэрээр философи эх хэлтэй, түүний дотор ерийн хэл буюу эрүүл утгатай ямар холбоотой байдаг талаар чухал чухал дүгнэлт

¹⁷ pee: Stuart Hampshire. The interpretation of Language. C.A.Mase. British Philosophy in Mid-Century, p.274-279

¹⁸ Hampshire, The Age of Reason (New York: New American Library of World Literature, Inc., 1956), p.12

хийжээ. Тухайлбал "Мур ба ерийн хэл" гэдэг өгүүлэлдээ Дж.Мурын философи аргын онцлогийг шинжлээд дараахь үндсэн дүгнэлтүүдийг хийсэн байдаг¹⁹. а). Зарим чухал философи хэллэг ерийн хэлийг буруу хэрэглэдгээсээ болоод ерийн хэлэнд харшилдаг. б). Тийм философи хэллэгнүүд төөрөгдөл төрүүлж, томъёоллынхоо бодит агуулгаараа үнэ цэнээ алдаж байдаг. Ерийн хэлэнд философи хэллэг тийнхүү харшилж буй нөхцөлд философи хэллэг нь худлаа байдаг. Яагаад гэвэл бид ямар нэг нөхцлийг тоочин илэрхийлэхдээ ерийн илэрхийллүүдийг амжилттай ашиглаж байдаг тул тэдгээр нь зөрчилгүй байж, зөв байхын шалгуур болж өгдөг.

Харин аналитик философийн өөр нэг төлөөлөгч Родерик Чизолм "Философичид ба ерийн хэл" гэдэг өгүүлэлдээ дээрх дүгнэлтүүдийн эхний хоёрыг үнэн, сүүлийнх нь худлаа гэж бичжээ²⁰. Чизолм ийм дүгнэлтээ зөвтгөхдөө: философи хэллэгнүүдийн агуулга нь ерийн хэлэнд хэрэглэгдэж буй зохиомжуудаас ялгаатай байдаг гэсэн юм.

Н.Малкольм ерийн хэлийг философи хэллэгнүүдээс илүү гэж үзэхдээ дараахь үндэслэгээг гаргасан юм. Үүнд: зарим хүмүүс ерийн хэл бол ерийн хүмүүсийн хэл мөн байдаг, тэд эмпирик (ажиглагдагч) баримтуудыг буруу мэдэрдэг гэдэг үзлээ үндэс болгоод: ерийн хэл бол таатай биш хэл мөн. Жишээ нь, хүн төрөлхтөн "дэлхий хавтгай" гэдэг хэлний илэрхийлэл ашигладаг байсан нь ерийн хэл бол "зохисгүй", "алдаатай" байдгийн баталгаа мөн гэсэн дүгнэлт хийж иржээ. Угтаа энд баримтанд холбогдох алдаа гарсан болохоос хэлний улмаас алдаа гарсан биш гэж Н.Малкольм бичсэн юм²¹. Тийнхүү Н.Малкольм ерийн хэлийг алдаа, зөрчил гаргадаг тухай үзлийг үл зөвшөөрчээ. Тэрээр өөрөө тодорхой нөхцлийг тоочин илэрхийлэхэд хэрэглэдэг илэрхийллүүдийг "ерийн хэлний илэрхийллүүд", харин нийтээрээ хэрэглэдэг (гэхдээ дандаа хэрэглэдэг байх албагүй) илэрхийллүүдийг "ерийн илэрхийллүүд" гэж тус тус нэрлэсэн байна²². Тэгээд: ерийн хэлний илэрхийллүүд аль нь ч бай зөрчилтэй байдаггүй. Яагаад гэвэл зөрчилтэй илэрхийлэл ямар нэг нөхцлийг тоочин илэрхийлэхэд хэрэглэгддэггүй. Харин ерийн илэрхийлэл аваас тодорхой нөхцлийг тоочин илэрхийлэхэд хэрэглэгддэг. Ерийн илэрхийллүүдээс ямар нэг зөрчилтэй үзлийг бүтээж болох авч тийм үзэл угтаа ерийн биш, өөрөөр хэлбэл тоочин илэрхийлэх (дескриптив) хэрэглээгүй байдаг хэмээн Н.Малкольм бичжээ.

Тийнхүү ерийн хэлэнд дотоод зөрчил байдаггүй гэж Н.Малкольм үзсэн байна. Энэ хэл ямар нэг худлаа юмыг баталж байгаа нь ч гэсэн түүний хэрэгтэйг гэрчилдэг хэмээн тэрээр дурдсан юм.

Философид (нэн түрүүнд уламжлалт философид) үүсдэг аливаа зөрчил, парадокс (гаж бодол) бол ерийн хэлийг буруу хэрэглэдгийн уршиг мөн бөгөөд, чухам хаана ийм алдаа гарав, эрүүл бодолд харшилдаг тийм хэллэгүүд яагаад гарч ирдэг вэ гэдгийг эмпирик баримтуудын тухай эрүүл бодолтой уялдуулан уг алдааг гаргагч нарт хэлж өгдөг байх нь философи анализын жинхэнэ зорилт байх ёстой. Тийм аналитик зорилтыг хэрэгжүүлэх хамгийн сайн судалгааны арга бол утгат чанар, бодол, бодомж дээр биш, харин Л.Витгенштейн заасны дагуу үгийг хэрэглэх, илэрхийллүүдийг эзэмших янз бүрийн арга дээр ажиллахуй мөн хэмээн Н.Малкольм заажээ.

Н.Хомский (Chomsky. 1928 онд төрсөн). Америкийн хэл шинжээч, лингвистик философич, "үүсвэрийн (generative) хэл зүйн дүрэм" гэгч онолын баримтлал боловсруулагч Ноат Хомский судалгаандаа хэллэгүүдийг тоочин шинжлэхийг биш, харин судалж буй хэлнээсээ онцолж буй тийм өгүүлбэрүүдийн хэрхэн үүссэн логик ба математик үйл явцыг авч үзэхийг гол зорилгоо болгодог байжээ. Түүний дэвшүүлсэн "үүсвэрийн загварын" үүднээс хандвал хэлний бүх зөв өгүүлбэрийг тогтоон төрүүлэх чадвар бүхий олон дүрэм байдаг. Улмаар хэлийг тоочин илэрхийлдэг уламжлалт бүдүүвч (схем)-ийг халж, хэлийг загварчлах үйл явцыг шинэчлэх ёстойг тэдгээр дүрэм гэрчилдэг ажээ. Уг загвар шаталсан (иерархи) зохиомжтой. Энэ зохиомж нь "шууд

¹⁹ См. об эмам: Н.Малкольм. Мур и обыденный язык. Аналитическая философия. Избранные тексты. М., 1993. С.84-99

²⁰ См. об этом напр.: там же, с.100

²¹ См. об этом напр.: там же, с.91-92

²² См. об этом напр.: там же, с.93

бүрдүүлэгч" үүсвэрүүд дагуу байдаг. Үүнд, уламжлалт үзлийн үүднээс авиа нь үгийн хэсгийг, үгийн хэсгүүд нь үгээ, үг нь холбоо үгийг, холбоо үг нь өгүүлбэрийг тус тус бүрдүүлдэг бол Н.Хомскийгийн загвар ёсоор синтаксисаас, тодруулж хэлбэл хамгийн их хийсвэр синтаксис бүтцүүдээс улам бүр холдох замаар фонологид (өөрөөр хэлбэл хэлний авиан байгууламжийн бүтцэн ба функциональ зүй тогтлуудад) шилжилт явагддаг.

Үүсвэрийн явцад өгүүлбэрийг "төлөөлөх (репрезентацийн) төвшин" янз бүр байдаг гэж Н.Хомский үзжээ. Тэдгээр түвшний дотор "гүн" ба "өнгөц" төвшингүүд хамгийн чухал нь гэж Н.Хомский үндэслэсэн байна. Үүнд: гүн бүтэц нь өнгөц бүтцээсээ илүү хийсвэр, нэгтгэн ерөнхийлсөн шинжтэй байдаг. Гүн бүтэц болбоос өгүүлбэрийн бүтцийг өөрийг нь үгээр болон тэр үгийг дараа нь "утгат чанарын тайлбараар" дүүргэхэд хангалттай тийм наад захын багтаамж бүхий хэмжээнд нь илэрхийлдэг. Харин өнгөц бүтцүүд болбоос тухайн өгүүлбэрийг өөрийг нь авиан зүйн үүднээс "тайлбарлахад" хангалттай тийм багтаамж бүхий хэмжээнд бүтээврийн (морфем) бүрэлдэхүүнийг нь тодорхойлогч олон цуврал хувиргалтын үр дүнд бий болдог гэж тэрээр үзжээ. (харин энэ үзэл хэрхэн шүүмжлэгддэгийг бид хойно өгүүлэх болно.)

Аливаа нийлмэл хэлц аваас элементэн (цөмөн) хэлцнүүдийн багцнаас тогтдог гэж Н.Хомский үзжээ. Гэхдээ тухайн хэлний дүрмүүдээр нөхцөлдсөн синтаксис холбоонууд хэлц дотор бий болж байдаг. Жишээ нь: а).охин алим идэж байна; б).алим охинд идэгдэж байна гэдэг хоёр өгүүлбэрийг авч үзье. Энэ хоёр өгүүлбэр мэдээлэл ижилтэй. Гэхдээ охин бол (а) өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн, харин (б) өгүүлбэрийн туслах гишүүн болж байна. "Гүн бүтцийн үүднээс хандвал "а", "б" хоёр өгүүлбэр болбоос охиныг гүн өгүүлэгдэхүүн (төлөөлөгч) болгож, харин алимыг гүн объект болгодог нэг өгүүлбэр мөн. Эдгээр хоёр өгүүлбэр бол гүн бүтцийн өнгөц хоёр хувилбар мөн. Энд "а" нь "идэвхтэй байгууламж" мөн. Харин "а"-гаас "б"-д шилжиж буй нь "идэвхгүй шилжилт (трансформаци)" мөн гэж Н.Хомский үзжээ.

Н.Хомский "шилжилтийг" шинжлээд 10-аад шилжилт байдгийг анзаарчээ. Жишээ нь: "охин алим иддэггүй"- охин алим иддэг гэдэг худлаа гэх мэт.

Шилжилтийг шинжлэх үйл ажиллагаа бол хоёрдмол утгат аливаа хэлцийг (өөрөөр хэлбэл утгат чанар, утга хоёр нь давхацсан юм уу ялгаатай буй үгнээс тогтдог хэлц бүхийг) шинжлэхэд чухал ач холбогдолтой гэж Н.Хомский үзсэн юм.

Н.Хомский 1965 онд "Синтаксисын тухай онолын зүйлс", 1968 онд "Хэл ба сэтгэхүй" гэдэг номыг тус тус хэвлүүлсэн нь түүний хувьд онолын баримтлалынх нь хөгжлийн шинэ шат болсон гэж зарим судлаач тайлбарласан байдаг²³. Үүнд: тэрээр хэлийг бодитойгоор тээх үйл ажиллагааны загвар зохиох зорилт тавихдаа компетенци (competence), хэрэглээ (performance) гэдэг хоёр ойлголт ашигладаг болжээ. Энд компетенци (хангалт) нь "яригч-сонсогч хэлээ эзэмшсэн мэдлэг", харин хэрэглээ нь "хэлийг тухайн нөхцөлд бодитойгоор ашиглахуй" гэдэг утгыг тус илтгэдэг. Компетенци бол субъект хэлэхүйдээ ашигладаг уялдаат дүрэмнүүдийг өөртөө багтаагч, төгсгөлгүй олон өгүүлбэрийг хязгаарлан ерөнхийлөх бололцоог хэрэглээ (performance)-нд олгогч мөн. Харин хэрэглээ нь компетенцийг практик дээр хангагч мөн.

Тийнхүү компетенци, хэрэглээ хоёрыг Н.Хомский ялгасан нь Ф.де Соссюр хэл, хэлэх хоёрыг ялгасныг санагдуулдаг. Гэвч эдгээр хосыг харгалзуулан адилтгаж болдоггүй. Учир нь, Ф. де Соссюрийн хувьд хэл бол янз бүрийн нэгж байдалт тогтолцоот багаж (өөрөөр хэлбэл тогтворт тогтолцоо) мөн ахул компетенци аваас үүсвэр үйл явцуудын тогтолцоо, тийнхүү динамик тогтолцоо байдаг. Энэ нь: хэлний дотоод бүтэц бол төрөлх шинжтэй байдаг бөгөөд тиймээс хэлийг эзэмших ажиллагаа бол хүний оюуны чадвараас үндсэндээ хамааралгүй байдаг гэж Н.Хомский үздэгтэй уялддаг. Бүхэлд нь дүгнэн хэлэхэд Н.Хомскийгийн үзлээр хэл үйлдэл хийдэг механизм бол хэрэг дээрээ синтаксис мөн бөгөөд энд яригддаг синтаксис аваас утгат чанарын агуулгаас бүрэн чөлөөлөгдсөн цэвэр хэлбэр бүтэцлэг синтаксис мөн.

²³ См. об этом напр.: В.М. Алпатов. История логических учений. М., 2001. с.313-324

Уоллес Л Чейф. Америкийн хэл шинжээч Уоллес Л Чейф бол дескриптив лингвистик, Н.Хомскийгийн "үүсвэрийн хэл зүйн дүрэм" хоёрыг голлон шинжилсний үндсэн дээр "утгат чанарын хэл зүйн дүрэм" гэдэг онолын баримтлал боловсруулжээ. Энэ явцдаа лингвистик философийн үүднээс чухал зарим үндэслэл дэвшүүлсэн байна. Тэдгээрийнх нь агуулгыг энд товч илэрхийлэх болно.

Бүтцийн хэл шинжлэлийн нэг нөлөө бүхий чиглэл болох Америкийн дескриптив хэл шинжлэл (лингвистик)-ийн төлөөлөгчид: хэлний авиан тал нь утгат чанарын талаа давамгайлдаг хэмээн үзсэнийг У.Л.Чейф үл зөвшөөрчээ. Тэрээр 1971 онд хэвлүүлсэн "Хэлний утгат чанар ба бүтэц" хэмээх томоохон бүтээлдээ хэлний авиан тал нь утгат чанараа давамгайлдаг гэх нь "авиан дэгсдүүлэг (phonetic bias)" мөн хэмээн үнэлсэн байна. Тэгээд У.Л.Чейф харин ч утгат чанар нь авиан талаа тодорхойлдог гэсэн үзлийг тууштай илэрхийлжээ. Үүнд: утгат чанарын (семантик) бүтэц хэрэгжиж буй үйл явц болбоос авиан (фонетик) төлөөллийг аяндаа бий болгодог. Харин утгат чанарын зөв бүтцийг өөрийнхөө байгууламжийн дүрмүүдээр аяндаа бий болгогч тийм авиан бүтэц гэж байдаггүй. Тийнхүү хэлэх үйлдлийн явцад утгат чанар, авиа хоёр тэгш биш гүйцэтгэлтэй байдаг. Утгат чанар нь хэлэх үйлдлийн эхэнд ч, төгсгөлд ч байдаг бол авиа нь дундаж байрлалтай. Яригч нь ямар нэг утгат чанарын бүтэц бүтээгээд түүнээ авиан болгож хувиргадаг. Сонсогч нь авиан бүтцийг үл бүтээж, тиймээс авиан бүтцийг утгат чанар болгон хувиргадаггүй. Тэр хүн болбоос яригчийн бүтээсэн утгат чанарыг өөрийнхөө хэлний авиан зүйн, бэлгэдмэл, утгат чанартай үйл явцуудыг ашиглах үндсэн дээр сэргээдэг хэмээн У.Л.Чейф бичжээ²⁴.

У.Л.Чейз бүтцийн хэл шинжлэлийн философи үндсийг тийнхүү шүүмжлэхдээ Н.Хомскийгийн дэвшүүлсэн үүсвэрийн хэл зүйн дүрмийн зарим санааг харгалзсан аж. Тухайлбал Н.Хомский структурализмын төлөөлөгчид таксономи (тодруулж хэлбэл янз бүрийн хэл болон хэлний нэгжүүдийг тодорхой дүрэм, зарчмуудын дагуу ангилдаг) аргуудыг ашиглаж байдгийг өрөөсгөл хэмээн үзээд хэлний тухай онолд хөгжил, өөрчлөлтийн үзлийг (динамизмыг) оруулж өгснийг У.Л.Чейф давтжээ. Бас компетенци, хэрэглээ хоёрыг Н.Хомский ялган үзсэнийг У.Л.Чейф өөрийнхөө онолд багтаасан байна.

Гэвч энэ бол үүсвэрийн хэл зүйн дүрэм, утгат чанарын хэл зүйн дүрэм хоёр дахь агуулга, арга зүйн чухал ялгааг үгүйсгэх үндэслэгээ болохгүй юм. Үүнд, Н.Хомский: синтаксис бүтэц аваас утгат чанарын болон ойлгохуйн асуудал руу орох юм бол хордсон хөрстэй болчихно. Гагцхүү формаль (хэлбэр бүтцийн) үндэс л хэл зүйн дүрэм бүтээх найдвартай суурь болдог гэж үзээд²⁵ янз бүрийн хэллэг төрөх үйл явц зөвхөн компетенцийн хүрээнд хэрэгжин, тийнхүү хэлний тогтолцооны хязгаараас хальдаггүй хэмээн тайлбарлаж байлаа. Харин У.Л.Чейф ийм үзлийг үл зөвшөөрөөд: синтаксис бүтцүүд аваас утга зүйн (семантик) хүрээнд бүрэлддэг. Зөв бүрэлдсэн утга зүй болбоос зөв зохион байгуулалттай өнгөц бүтцүүдэд болон тийм бүтцүүдийн авиан төлөөллүүдэд хүргэх болно гэж өгүүлсэн байдаг. Тийнхүү У.Л.Чейф үгийн төдийгүй хэл зүйн дүрмийн утга зүйг Н.Хомскийн "гүн бүтцүүдэд" сэргүүлэн тавьжээ.

Дүгнэн дурдахад хэлний янз бүрийн нэгжийг хэрэглэхэд төдийгүй тэдгээр нэгжид өөрсдөд нь, тэдгээрийн дотоод байгууламжид нь тогтвор дахь хувьслын мөч агуулагддаг гэж У.Л.Чейф үзжээ.

Дж.Сёрл (Searle. 1932 онд төрсөн). Америкийн философич Дж.Сёрл бол Дж.Остины лингвистик философийн нөлөөг ихээхэн авсан аж. Тэрээр хэлээр бүтсэн үйлдлүүдийг ангилахдаа "иллокутив зорилго" гэдэг ойлголтыг ашигласан байна. Тэгээд хэлний утгат чанар аваас тус тус үг юм уу өгүүлбэрт биш, харин бие хүмүүс хоорондын

²⁴ См. об этом: Уоллес Л.Чейф. Значение и структура языка. Пер. С.англ. М., 1975. с.74-75

²⁵ См. Н.Хомский. Синтаксические структуры – Новое в лингвистике сборник. М., 1962, с.504-512

хамаарлын явцад, бүхэллэг "хэлэх үйлдлийн" хүрээнд сэргээн үйлдвэрлэсэн тийм жич жич үг ба өгүүлбэрт байдаг гэж үзжээ.

Тийнхүү Дж.Сёрл утгат чанар бол үгэнд тогтмол, төрөлх байдаг биш, харин хэлэх үйлдлийн бүтээгдэхүүн мөн гэж үзжээ.

Резюме. В начале своей статьи её автор подчёркивает различие таких понятий, как "философия языка (philosophy of language)" и "лингвистическая философия (linguistics philosophy)" и отмечает важную рациональность сделанного отдельными исследователями подразделения представителей лингвистической философии на первое второе поколение. В основном в данной статье ставится цель раскрытия содержания важных лингвистическо-философских положений таких главных представителей 2-ого поколения лингвистической философии, как Дж.Уизом, П.Стросон, Дж.Остин, Ст.Хэмпшайр, Н.Малкольм, Н.Хомский, У.Л.Чейф и Дж.Сёрл на основе сравнительного анализа некоторых подходящих философских положений этих философов.

Ном зүй

1. В.М.Алпатов. История лингвистических учений. М., 2001
2. Лингвистический энциклопедический словарь. М., 1990
3. Н.Малкольм. Мур и обыденный язык.-Аналитическая философия. Избранные тексты. М., 1993
4. Джон Остин. Избранное. М., 1999
5. Дж.Сёрл. Создание, мозг и наука.-Путь, 1993, №4
6. Н.Хомский. Синтаксические структуры. -Новое в лингвистике. Сборник. М., 1962
7. Уоллес Л Чейф. Значение и структура. Пер. с англ. М., 1975
8. В.Я.Шевякова. Актуальное членение предложения.-Лингвистический энциклопедический словарь. М., 1990
9. E.A.Burtt. Descriptive metaphysics.-Mind, 1963 vol. 72, №285
10. Stuart Hampshire. The Ade of Peason. N.Y., 1956
11. P.E.Strawson. Introduction to logical theory.L.- N.Y., 1952
12. P.E.Strawson. Individuals: An essay in descriptive metaphysics. L., 1959